

ГАЗРЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Байгууллагын алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах стратегийн зорилго, зорилтыг төлөвлөж байна. Үүнд:



СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ХҮРЭХ ҮР ДҮН

Стратегийн зорилго 1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх.

- 1.1. Нийслэлийн түр хоргодох орон байраар хангах албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, бэлэн байдлыг ханган ажиллана.
- 1.2. Гамшгийн үед байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэг, өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, нутгийн захиргааны байгууллага, салбар хоорондын харилцан ажиллагааг оновчтой зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж ажиллана.

Стратегийн зорилго 2. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- 2.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 2.2. Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, шинжлэх ухаан, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж хотын хэт төвлөрлийг бууруулна.
- 2.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- 2.4. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулна.
- 2.5. Барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, хүчитгэлийн зураг боловсруулж, лаборатори байгуулна.

Стратегийн зорилго 3. *Монгол Улсын үндэсний хөгжлийн бодлоготой, нийслэл хотын төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.*

- 3.1. **Дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна.**

Стратегийн зорилго 4. *Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.*

- 4.1. Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө болон өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулан батлуулна.
- 4.2. Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ.
- 4.3. Ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр барина.
- 4.4. Одоо байгаа ус хангамжийн усан сан, шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.
- 4.5. Ус хангамжийн шугамыг шуудуу ухалгүй доторлох төслийг хэрэгжүүлж дуусгаж, зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулна.
- 4.6. Шинээр цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулах бөгөөд хуучин байгууламжуудад техник технологийн шинэчлэлт хийнэ.
- 4.7. Цахилгааны шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, сүлжээний хамрах хүрээг өргөтгөн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.8. Дулаан, цахилгааны станц шинээр барих, өргөтгөх, технологийн шинэчлэл хийнэ.
- 4.9. Дулааны гол магистраль шугамын урт, дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.
- 4.10. Хатуу түлшний халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбох, хийн түлшинд шилжүүлэх, хийн хангамжийн хэрэглээг нэвтрүүлэх талаар төлөвлөлтөд тусган хэрэгжүүлнэ.
- 4.11. Мэдээлэл холбооны нэгдсэн төвүүдийг байгуулан өндөр хурдны сүлжээнд холбож, ухаалаг хот байгуулах нэгдсэн цагариг сүлжээ үүсгэн, зохион байгуулалтыг сайжруулна.

Стратегийн зорилго 5. *“Цахим засаглал” бодлогын зорилтыг дэвшүүлж байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.*

- 5.1. Газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах “Чанарын удирдлагын тогтолцоо”-ны баримт бичиг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 5.2. Байгууллагын үйл ажиллагаанд цахим технологийг нэвтрүүлж иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх, хот байгуулалт, төлөвлөлтийн мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэнэ.

Стратегийн зорилго 6. *Хүний хөгжил, байгууллагын хүний нөөцийн бодлогыг сайжруулж ажлын бүтээмжийг дээшлүүлнэ.*

- 6.1. Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээний үнэлгээнд үндэслэн богино, дунд хугацааны сургалтад хамруулах, тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлнэ.

- 6.2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлнэ.
- 6.3. Албан хаагчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, тэдний нийгмийн баталгааг үе шаттайгаар дээшлүүлнэ.
- 6.4. Төрийн албаны тухай хууль, журмын хүрээнд Газрын хөдөлмөрийн дотоод журам болон шаардлагатай дүрэм, журмыг шинэчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.